БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН
ДАРГА Т.АЛТАНХУЯГ

2025 оны 04 дүгээр сарын "14"-ны өдөр

НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Бараа материалын нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт	Зураг /эсхүл түүнтэй дүйцэх/
1	Цагаан маск /1 удаагийн/	65569	Цанталт бууруулдаг, Нарийн тоос тоосонцорыг 95% шүүдэг, N95 ба FFP1.FFP2 байна.	
2	Хошуувчны шүүлтүүр /Багц дотроо 20ш/	1957	Сольдог хагас шүүлтүүртэй FFP1, FFP2, FFP3 MNS 5620:2006 стандартыг хангасан байна.	
3	Хошуувч /саарал/	769	1. Хавхлагтай хошуувчийн тоос шүүгчийн давхар нь 10 ба түүнээс дээш байх шүүх чадвар FFP2 байна. Амьсгалахад чөлөөтэй , нүүр болон ам орчмын арьсанд хөлөргөх, норох зэрэг сөрөг нөлөөгүй, өнгө үзэмжтэй, хөнгөн, шүүх чадвар нэн сайн, эд ангийг сольж засварлах боломжтойгоор хийгдсэн байна. 2. Лабораторийн ажилчдад зориулсан химийн бодисын уур манан, ууршилтаас амьсгалын замыг хамгаалах дээд зэрэглэлийн 3M 7502 шүүлтүүртэй байна.	
4	Чихэвч /дуу намсгагчтай/	106	Чихний дэлбээ, сувгийг хамтад нь хамгаалах шуугианыг бууруулах, чихэвч нь хоорондоо уян холбогдож, чихний дээр хөдөлгөөнгүй шуугиан нэвтрэх зайгүйгээр сууж, шуугианы хүчийг бууруулна. Харшил үзүүлэхгүй, холгох, өвтгөх зэрэг механик нөлөөлгүй, эвхэгддэг авч явахад хялбар, зөөлөвчтэй хийгдсэн байна.	
5	Салхи туяаны шил /уул/ 7,470,000	415	99% хэт ягаан туяаны хамгаалалттай. Зурагдалтаас хамгаалсан бүрхүүлтэй, цантдаггүй байна.	

6	Гагнуурын брезентэн /элгэн/ хувцас	75	Цахилгаан ба хийн гагнуур хийхэд хөдөлгөөнд хийхэд саад учруулахгүй, хүнийг шаардагдах түвшинд хамгаалахаас гадна биед дээд зэргээр тохиромжтой, гаж нөлөөлөл үзүүлэхгүй, галд тэсвэртэй, размерийн сонголттой байна.	
7	Комбинзон юүдэнтэй /тосны/	224	Тос, тоос нэвтэрдэггүй, хөлрөгдөггүй, зузаан женсэн материалтай, размерын сонголттой байна.	
8	Борооны цув	108	Бүтээгдэхүүнийг эдлэх хугацааны туршид материал болон эд ангиудыг нэгтгэсэн хэсгүүд бөх бат, тэсвэртэй чанараа 15-аас дээш хувиар алдахгүй байх, -Хур тунадаснаас хамгаалах зориулалтын хувцас нь ус тэсвэрлэх тэсвэр нь 1800Па-аас, усны урсгалын үйлчлэл даах тэсвэр нь 3000Па-аас дээш байна. -Ус үл нэвчих давхаргаар бүрсэн синтетик даавуугаар хийсэн гэрэл ойлгогч туузтай цув байна. Материалын үндсэн утасны бүтэц: 100% полиэфир; Бүрээс: 100% поливинилхлорид; Материалын нягт /хамгийн бага/: 305±25г/м2; Тохирлын баталгаа: ГОСТ 27643-88, EN40, EN 343, EN 1149-1, ГОСТ 12.4.134-83; Тохирлын баталгааг Монгол улсын стандартчилал техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу тохирлын баталгааг хийлгэсэн байна	
9	Усны гутал	131	Ус нэвтэрдэггүй, тос, түлш, хүчилд тэсвэртэй. 200 жоул цохилт даах пластик хамгаалалттай. Төрөл бүрийн орчинд өмсөхөд тохиромжтой усны гутал байна.	

10	Усны комбинзон	11	Ус нэвтрүүлдэггүй. Урдаа нэг цахилгаантай, шуурга болон үер усны аюулд өмсөхөд зориулагдсан. Ханцуйг тохируулж болдог. Өмсөхөд хялбар, размерын сонголттой байна.	
11	Үйлчлэгч табочик	21	100 хувь арьсан чийг татахгүй, зориулалтын нумтай, удаан зогсоо ажил хийдэг хүмүүст нуруунд ачаалал өгөхгүй, хальтрахгүй размерын сонголттой байна.	
12	Нүдний шил /тоосны/	861	1. Доргио болон тос нарийн хэмжээний тоосноос хамгаалсан, 99% хэт ягаан туяаны хамгаалалттай. Зурагдалтаас хамгаалсан бүрхүүлтэй. Цанталтын эсрэг хамгаалалттай. Метал эд анги ороогүй. Уян гартай байна. 2. Лабораторийн ажилчдад зориулсан химийн бодисын ууршилтаас хамгаалсан, нарийн ширхэгтэй тоосонцор, цацраг туяанаас хамгаалсан шил байна. 3M 334AF /2 ширхэг/	
13	Нүүрний хамгаалалт /Нүүрэвч/	172	Нүүрэвч нь өнгө үзэмжтэй, хөнгөн, нүүрэнд хор үзүүлэхгүй хийцтэй байна. 12 м/с-190м/с хүртэл хурдтай цохилтыг тэсвэрлэх чадвартай, 1-5 мм зузаан, нүүрэвчийн харах талбай 200х200 мм байна. Хаалт нь поликорбанат, ацетатаар хийгдсэн тунгалаг биетээс бүрдэнэ. Тохирлын баталгаа: EN 166:2001-д нийцсэн. Тохирлын баталгааг Монгол улсын стандартчилал техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу баталгааг хийлгэсэн байна	
14	Гагнуурын баг	52	➢ Гэрэл бууруулагч дэлгэцийн харах талбай 44*90 мм-ээс багагүй ➢ Автомат гэрэл бууруулагчтай дэлгэцийн зайны ажиллах хугацаа 1500 цагаас багагүй ➢ Автомат гэрэл бууруулах горимын сонголт 8-12	

			➢ 14Гэрэл бууруулагч дэлгэц идэвхжих хугацааны дээд хязгаар 0,1мс /+23С/ ➢ Дэлгэцийн гадна хамгаалалтын стандарт EN 166 нийцсэн. 1 – Харааны зэрэглэл 1 буюу дээд B – Дунд зэргийн цохилтонд тэсвэртэй (120м/с) T – Агаарын эрс тэс нөхцөлд туршигдсан ➢ Дэлгэцийн дотор талын хамгаалалтын стандарт EN 166 1 – Харааны зэрэглэл 1 буюу дээд S – Хүчитгэсэн линз Гагнуурын багны их биеийн стандарт EN 175 B - Дунд зэргийн цохилтонд тэсвэртэй (120м/с) Тохирлын гэрчилгээ: EN 379-д нийцсэн. Тохирлын баталгааг Монгол улсын стандартчилал техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу баталгааг хийлгэсэн байна 3M Speedglass 100 загварын багтай дүйцэхүйц байх.	
15	Галд тэсвэртэй бүтээлэг	8	MNS 5566:2005 стандартын шаардлагад нийцсэн байх	
16	Каск	192	Хамгаалалтын дуулга нь дараах шаардлагуудыг хангах ёстой. Үүнд: ➢ 50 Дж цохилтын хүч үйлчлэхэд хамгаалалтын дуулга нь толгойд 5 кН-оос ихгүй хүчийг дамжуулах ёстой, мөн 30 Дж хүчтэй хурц ирмэг бүхий зүйлс дээрээс унахад тэдгээр нь толгойг цохихгүй байх ёстой; ➢ Хамгаалалтын дуулганы их бие нь цахилгаан гүйдэлтэй эд ангид хүрэхэд 50 Гцийн давтамжтай 440В-оос багагүй хүчдэлийн хувьсах гүйдлээс хамгаалах ёстой; ➢ Хамгаалалтын дуулга нь үйлдвэрлэгчээс тодорхойл-сон дулааны дээд доод хязгаарт	

			хамгаалах чадвараа хадгалах ёстой. Хамгаалалтын дуулга бүр түүнийг хэрэглэх температурын дээд доод хязгаар болон цахилгаан тусгаарлах чадварыг заасан арилахааргүй (сийлсэн, цохисон) тэмдэг, тэмдэглэгээтэй байх; ➢ Хамгаалах дуулга нь толгойноос унах, холбирохоос сэргийлсэн бэхэлгээтэй байх; ➢ Хамгаалах дуулга эрүүн доогуурх бүчтэй бол түүний өргөн нь 10 мм-ээс багагүй байх ба бүч болон түүний бэхэлгээний бат бэхийн дээд хязгаар нь 150 - 250 Н байна; ➢ Туршилтын үед хажуугийн хэв гажилт нь 40 мм-ээс ихгүй, үлдэгдэл хэв гажилт нь 15 мм-ээс ихгүй байх; ➢ Хамгаалах дуулгыг толгойдоо анх тохируулан өмссөнөөс хойш хэрэглэх нийт хугацааны туршид түүний тохиргоо өөрөө өөрчлөгдөх ёсгүй; ➢ Үйлдвэрлэгч толгой хамгаалах хэрэгслийн ашиглалтын баримт бичигт түүнийг хэрэглэх температур, нөхцөл, цахилгаан тусгаарлах чадвар зэргийг заасан байх ёстой. ➢ Өндөр болон (эсвэл) нам температурын үйлчлэл, дулааны цацрагийн үйлчлэлээс хамгаалах дуулга нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: ➢ Хамгаалалтын дуулга нь хайлсан металлын шүрсдэс, очийг дотогш нэвтрүүлдэггүй байх (их биед хайлсан металлын шүрсдэс хүрснээс хойш 5с-ын дараа дөлний шаталтыг зогсоодог байх ёстой); ➢ Хамгаалалтын дуулга нь ердийн агааржуулалттай байх бөгөөд хэрэв агааржуулалтгүй бол доторх чийгийг шингээх хэрэгсэлтэй байна; ➢ Өндөр температуртай орчинд гүйцэтгэх ажилд зориулагдсан хамгаалалтын дуулга нь үйлдвэрлэгчийн	

			заасан гадна агаарын температурын дээд доод хязгаарт өөрийн хамгаалах чадвараа хадгалах ёстой; Тохирлын баталгаа: EN 397 Тохирлын баталгааг Монгол улсын стандартчилал техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу тохирлын баталгааг хийлгэсэн байна. 3M H-700 загварын дуулгатай дүйцэхүйц байх.	
17	Дохионы фанарь	21	Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай байна.	
18	Аюулгүй тууз	31	Яаралтай, түр хугацаанд засвар үйлчилгээ хийх, зам хааж нээх, хашлага хаалт хамгаалалтанд хэрэглэнэ.100х10 хэмжээтэй	
19	Хальтиргаанаас хамгаалах дрож	170 м	Өвлийн улиралд бетонон шал, тавцан дээр дэвсэж хальтиргаа гулгаанаас хамгаалах зориулалттай.	
20	Каскны дотор малгай	689	Савлахын ачигч, буулгагч, гагнуурчдад зориулсан каскны дотор малгай, тоос нэвтрүүлдэггүй, хөлөргөдөггүй даавуун материалтай байна.	
21	Чихний бөглөө	3838	Чихний бөглөө нь нэг удаагийн ба олон удаа хэрэглэгддэг, полимерен материалаар хийгдсэн хооронд нь холбосон уяатай байна. Чихний сувгийн хэлбэрт амархан ордог байх, үйлдвэрийн дамжлага, өрөө тасалгаан дахь дуу чимээг 35,4-44,8 децибел хүртэл бууруулах чадвартай байна.	

22	Хорт утааны баг 486,000	9	Хүний амьсгалын замын эрхтэнг хорт утаа, химийн хортой ууршилт, тоосноос хамгаалах үндсэн зориулалттай байна. Амьсгалын эсэргүүцэл 195L, 800 PA-аас ихгүй, утаа дамжуулах коэффициент 5%-аас ихгүй, CO 0,5-1% байна.	
23	Галд тэсвэртэй хувцас	12	Хөнгөн цагаан тугалганы нийлмэл галд тэсвэртэй шилэн хөвөн, 500g+-10g/m2, галд тэсвэртэй, тусгаарлагчтай, арамид материалтай, дотоод давхарга нь доторлогооны зориулалттай байгалийн гаралтай материалаар хийгдсэн, 1000 градусын цацраг туяад дулаан тэсвэрлэлттэй жин нь 5,7 кг хүртэл байна.	
24	Гагнуурын автохийний шил /бууруулагчтай	15	Хийн гагнуурын ажил, металл зүсэх ажил хийж байх үед хэт ягаан, улаан туяа, халуун биет, бусад механик гэмтлээс нүдийг дээрээс доороос хажуугаас хамгаалах зориулалттай. Нүдний шил нь галд тэсвэртэй их бие, хэт ягаан туяанаас хамгаалсан поликарбонат, ацетат, обтюраторaас бүтсэн хамгаалалтын линз, нүүрэнд нягт наалдсан, толгойн хэмжээгээр тохируулж болох галд тэсвэртэй бэхэлгээ зэргээс бүрдэнэ. Мөн гэрлээс хамгаалсан давхар линзтэй (сөхдөг) байж болно. Линз нь харааны гажуудал үүсгэхээргүй харааны 1-р зэрэглэлд таарсан байна. 1-р зэрэглэлээс доош нөхцөлд хэрэглэхийг хориглоно. Нүдний шилийг ажлын бүх өдөр зүүхэд нүдэнд ядаргаа үүсгэхээргүй хийгдсэн байх ёстой. Нүдний шилний иж бүрдэлд шил арчих даавуу, хайрцаг дагалдаж болно. Тохирлын баталгаа: EN 166 Тохирлын баталгааг Монгол улсын стандартчилал техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу Монголын эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар тохирлын баталгааг хийлгэсэн байна	

25	Өндрийн хамгаалалтын бүс	20	Ардаа 1 D- хэлбэрийн цагираг нь гогцоотой. Нурууны зөөлөвчтэй, хоёр талдаа D- хэлбэрийн цагираг нь гогцоотой. Полиэстр материалаар хийгдсэн, ган тоноглолтой, Хөл нурууны зөөлөвчтэй, дээд зэргийн бат бөх байна. MNS 4931:2001 стандартыг хангасан байх.	
26	Дарцаг	8	30х20 хэмжээтэй улаан даавуун дээр шар ойлгогчтой байна. /Улаан дэвсгэртэй-4, шар дэвсгэртэй-4/	
27	Олс	600 м	Олсны төрөл: Дан статик олс Диаметр: 12мм Материал: Нилон 66 Тасрах хүч: 25 килоньютон Суналт: 2.8% Гулгалт: 0% Эрчлэлт: 48	
28	Элгэвчтэй брензэнтэн хормогч	28	Хормогч нь жэнсэн сунадаггүй материалтай, 2 давхар давхарлагаатай, 2 хос оёдолоор дарж оёсон, энгэр хэсэг нь дугуй, хормой хэсгийн 2 тал дугуй байна.	
29	Ханцуйвч	829	Техникийн чиглэлийн ажилтнууд болон савлахын ачигч, буулгагч нарт зориулагдсан, тос нэвтрүүлдэггүй, оёдол сайтай элэгдэлд тэсвэртэй материалаар хийгдсэн урт нь 35-40 см-ийн урттай байна.	
Нийт төсөв				306.503.100 төгрөг

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:
ИНЖЕНЕР /ХАБЭА-Н ХЯНАЛТЫН/ Л.МЯГМАРЦЭЦЭГ